

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангарагийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/;
- Тухайн орон тоонд шилжин ажиллахыг хүссэн өргөдөл.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 цагаас 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: taz_enkhchimeg@burtgel.gov.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 11321242, 99007339

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт (2025.12.15)

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Санхүү, үйлчилгээний хэлтэс	Хэлтсийн дарга	1	Удирдах	Ахлах түшмэл	Дээд	-Нягтлан бодох бүртгэл (0411); -Санхүү (0412); -Эдийн засаг (0311)	-Дунд шатны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх; -Мэргэшсэн нягтлан бодогч байх.	-Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.
2	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч	1	Гүйцэтгэх	Дэс түшмэл	Дээд	-Эрх зүй (0421)	Шаардахгүй	Шаардахгүй.
3	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс	Иргэний улсын бүртгэгч	2	Гүйцэтгэх	Дэс түшмэл	Дээд	-Эрх зүй (0421); -Эдийн засаг (0311); -Хүн ам зүй (031406); -Нийгмийн ажил (0923); -Нягтлан бодох бүртгэл (041101); -Бизнесийн удирдлага (041301); -Хэл эзэмшихүй (0231); -Математик, статистик (054)	Шаардахгүй	Шаардахгүй.
4	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч	4	Гүйцэтгэх	Дэс түшмэл	Дээд	-Эрх зүй (0421)	Шаардахгүй	Шаардахгүй.